*Сумын Засаг даргын 2025 оны 09*
*дүгээр сарын 19 –ний өдрийн А/166*
*тоот захирамжийн 1-р хавсралт*

Хуш модны сатрын дуудлага худалдааг зохион
байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч: СДОА-ийн дарга - Г.Гантуяа

Нарийн бичиг: СДОА-ийн бичиг хэрэг нярав - Б.Солонго

Гишүүд: БОУХ Байцаагч – Б.Мөнх-Очир

СДОА-ийн ойн инженер – Б.Батчимэг

*Сумын Засаг даргын 2025 оны 09*
*дүгээр сарын 19. –ний өдрийн А/166*
*тоот захирамжийн 2-р хавсралт*

Улсын тусгай хамгаалалттай газар нутаг хамаарахгүй ойгоос ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар хуш модны самрыг бэлтгэх дээд хэмжээ

| Аймгийн нэр | д/д | Сумын нэр | Ахуйн зориулалтаар түүж бэлтгэх дээд хэмжээ /кг/ | Үйлдвэрлэлийн зориулалтаар түүж бэлтгэх дээд хэмжээ /кг/ |
|---|---|---|---|---|
| Хэнтий аймаг | 1 | Батширээт | - | 333063 |

Сумын Засаг даргын 2025 оны 09 дүгээр сарын 19 -ний өдрийн А/166 тоот захирамжийн 3-р хавсралт

Батширээт сумын хуш модны самрын дуудлага худалдааны багц

| № | Багцын дугаар | Хэмжээ кг | Ашиглах нөөц % | Дэнчингийн үнэ | Дуудлага худалдааны анхны үнэ | Хугацаа |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 1 | 50000 | 15 | 17500000 | 35000000 | 2025.09.18 10 цагт |
| 2 | 2 | 50000 | 15 | 17500000 | 35000000 | |
| 3 | 3 | 50000 | 15 | 17500000 | 35000000 | |
| 4 | 4 | 50000 | 15 | 17500000 | 35000000 | |
| 5 | 5 | 50000 | 15 | 17500000 | 35000000 | |
| 6 | 6 | 50000 | 15 | 17500000 | 35000000 | |
| 7 | 7 | 33063 | 10 | 11572050 | 23144100 | |
| **Нийт** | | **333063** | **100** | 116572050 | 233144100 | |

**ХЭНТИЙ АЙМГИЙН**
**БАТШИРЭЭТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2025 оны 09 сарын 19 өдөр Дугаар А/166 Батширээт сум

Дуудлага худалдаа зохион байгуулах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1 дэх заалт, Зөвшөөрлийн тухай хуулийн 5,6 дугаар заалт, Ойн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.5, Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2024 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн А/737 тоот тушаал Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн Хуш модны самар бэлтгэх хэмжээ тогтоох тухай 2025 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн А/706 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хуш модны самрыг бэлтгэх тусгай зөвшөөрлийг олгох дуудлага худалдаа зохион байгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, үйлдвэрлэлийн зориулалтаар бэлтгэх хуш модны самрын хуваарийг хоёрдугаар хавсралтаар, хуш модны самрын дуудлага худалдаа явуулах багцын мэдээллийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай .

2. Үйлдвэрлэлийн зориулалтаар бэлтгэх, тээвэрлэх хуш модны самрын тусгай зөвшөөрлийг олгох дуудлага худалдааг 2025 оны 09 дүгээр сарын 23,24-ний дотор хууль журамд нийцүүлэн зохион байгуулж, дуудлага худалдааны тайлан мэдээг тайлагнаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, сум дундын ойн ангийн дарга (Г.Гантуяа) -д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Төрмөнх)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Б. АЛТАНГЭРЭЛ

2325010025